

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Огноо: 2024.11.19

“ЦОГТЭЦИЙ СУМ ДАХЬ ХЭЛТЭСТ ТАВИЛГА, ТОНOG ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ  
АЖИЛ  
ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шадгаруулалт  
Гэрээний дугаар: ӨМАОБГ/20240202006

Даланзадгад

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2024-11-19

Тендер шалгаруулалтын нэр: “Цогтцэций сум дахь Онцгой байдлын хэлтэст тавилга, тоног төхөөрөмжхийлүүлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар: ӨМАОБГ/20240202006

Өмнөговь аймгийн Онцгой байдлын газарт : “Цогтцэций сум дахь Онцгой байдлын хэлтэст тавилга, тоног төхөөрөмжхийлүүлэх ажил”-ыг хийх тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000** /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 1 жилийн дундаж нь төсөвт өртгийн 50%-аас багагүй

**Ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:**1

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Төсөвт өртгийн 50%-аас багагүй

**Санхүүгийн тайлан үзэх жилийн тоо:** сүүлийн 2 жил /2023/  
Тусгай зөвшөөрөл шаардлагүй.

Тендерийг 2024 оны 11-р сарын 19-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2024 оны 11-р сарын 25-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй. Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс авч болно.

**ӨМНГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР  
80877111**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар,

- хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дунд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ</b>	<b>Нэг. Ерөнхий шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	Захиалагч нь: “Өмнөд бүсийн төв өмнөговь аймгийн онцгой байдлын газар”
<b>ТОӨЗ 1.2</b>	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: Нэр: “Цогтцэций сум дахь Онцгой байдлын хэлтэст тавилга, тоног төхөөрөмжийлүүлэх ажил”-ыг гүйцэтгэх дугаар: <b>ӨМАОБГ/2024202006</b>
<b>ТОӨЗ 1.3</b>	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: <b>2024 оны 12-р сарын 31-ны өдөр</b>
<b>ТОӨЗ 1.4</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөв <b>50,000,000 /Тавин сая төгрөг/</b>
<b>ТОӨЗ 1.5</b>	Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагагүй. Үүнд:
<b>ТОӨЗ 5.1</b>	Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримыг тендерийн хамт ирүүлэх. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбарыг наториатоор гэрчилүүлж ирүүлэх/</li> <li>2. Татварын албаны тодорхойлолт /татварын өргүй тухай/</li> <li>3. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>4. Харилцагч банкны тодорхойлолт /өр, зээлийн тухай/</li> </ol>
<b>ТОӨЗ 5.2</b>	Санхүүгийн болон татварын тайлан ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 1 жил буюу 2023 оны тайлан.</b>
<b>ТОӨЗ 5.3</b>	Шаардахгүй

<b>№</b>	<b>Гэрээний дугаар</b>	<b>Захиалагч, үйлчлүүлэгчийн нэр, холбоо</b>	<b>Гүйцэтгэсэн ажлын нэр, дууссан</b>	<b>Гэрээний үнэ</b>	<b>Ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан</b>
<b>/Загвар хүснэгтийн дагуу ирүүлнэ/</b>					
<b>ТОӨЗ 5.2</b>		<b>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай</b>			
<b>ТОӨЗ 5.3</b>		Шаардахгүй			
<b>ТОӨЗ 6.2</b>		Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Нэг багцаас бүрдэнэ. Зөвхөн эх хувийн тендерийн материал ирүүлэнэ.</b>		<b>Хоёр. Тендерийн бичиг баримт</b>	
<b>ТОӨЗ 10.1</b>		1. Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Өмнөговь аймаг Онцгой байдлын газрын байр 3 давхарт санхүүгийн өрөө утас: 80877111</b> 2. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлт хүлээн авах хугацаа: тендер нээх хугацаанаас өмнө хуанлийн 3 хоногоос багагүй байна.			
<b>ТОӨЗ 13.1</b>		Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь: <b>Монгол хэл байна</b>			
<b>ТОӨЗ 14.1</b>		Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг ирүүлнэ.Үүнд:  1. Захиалагчийн хяналтын зардал, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож, барилгын ажлын төсөө, ажил гүйцэтгэх технологи аргачлал, ажлын график ирүүлнэ. 2. Үнэлсэн үе шатны ажлын хуваарийг мэргэжлийн мэргэшсэн төсөөвчнөөр хийлгэж гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан байна. 3. Тендерийн баримт бичгийн 5,6-р бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ. 4. Инженер техникийн голлох ажилчдыг томилсон захирлын тушаалын хуулбар			

<b>ТОӨЗ 18.1</b>	Тендерийн валют: <b>Төгрөг байна.</b>
<b>ТОӨЗ 21</b>	Тендерийн баталгааны үнийн дүн: шаардана. Хүчинтэй байх хугацаа: 2024 оны 12 -р сарын 31 -ны өдрийг дуустал
	Гурав. Тендер ирүүлэх
<b>ТОӨЗ 23.1</b>	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:  <b>Байгууллагын хаяг Өмнөговь аймаг Онцгой байдлын газар санхүү Утас - 80877111</b></p> <p>Тендер хүлээн авах этгээд: Б.Баттуяа  Жич: Уг тендер нь харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах журмаар зохион байгуулагдаж байгаа тул зөвхөн цахим тендерийн материалыа ирүүлнэ үү</p>
<b>ТОӨЗ 24.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:  Огноо: 2024 оны 11 дугаар сарын 25-ны өдөр  Цаг: 10цаг 00 минут-аас өмнө <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> гэсэн хаягаар цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>
	Дөрөв. Тендерийг нээх, Үнэлэх
<b>ТОӨЗ 27.1</b>	<p>Тендерийн нээлт хийх хаяг нь дор өгөгдөв. Үүнд:  Байгууллагын хаяг: <b>Өмнөговь аймаг Онцгой байдлын газар санхүү Утас - 80877111</b></p>

<b>ТОӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
ТОӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар</li> <li>Харилцагч банкны тодорхойлолт 2024 оны 02 сарын байдлаар</li> <li>Харьяа аймаг, дүүргийн татварын хэлтэст өргүй байх /2024 оны 02 сарын байдлаар QR кодтойгоор/</li> <li>Сүүлийн 1 жилийн буюу 2023 оны борлуулалтын орлого 50 хувиас багагүй байх</li> <li>Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраа өр төлбөргүй талаар тодорхойлолт</li> <li>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</li> </ol>

<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн тоон гарын үсгийг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (<b>PDF</b>)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Огноо: <b>2024-11-25</b></p> <p>Цаг: <b>10:00 цаг хүртэл</b></p>
<b>ТОӨЗ 2.2</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Өмнөговь <b>аймаг Онцгой байдлын газар санхүү</b>  <b>Утас - 80877111</b></p> <p>Огноо: <b>2024-11-25</b></p> <p>Цаг: <b>10:30 цаг</b></p>
<b>ТОӨЗ 3.1</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p>

**ӨМНӨД БҮСИЙН ТӨВ-ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН АЛБА  
ХААГЧ НАРТ ШААРДЛАГАТАЙ ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА**

2024.11.13

Даланзадгад

№	Цол, овог, нэр	Шаардл агатай техник хэрэгсэ л	Марк, үзүүлэлт	Зураг	Үнэ	Тайлбар
<b>Онцгой байдлын газар</b>						
1  x/ч Б.Дэнзэн	Тог бариж	Тог тасарсан үед 1 цаг ашиглах 2700 Watts / 3000VA			6,600,000	Өндөр хүчин чадалтай АОК-ын цахилгаанаар бүрэн хангах
		Өнгөт принтер	3 үйлдэлт /Хэвлэх, Хувилах, Сканер/		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
		Компью терын гар, хулгана	Зайнаас холбогддог		80,000	АОК-ын хурлын ухаалаг дээр
		Ус буцалга гч	Кофе chanagчтай		150,000	АОК-ын хурал бусад зөвлө гишүүдэд цай өгөх
		Компью тер	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер нийтийн core i3 5 үеийн үзүүлэлттэй
		Ухаалаг индэр	Ухаалаг индэр SP- Y670		9,900,000	АОК-ын хуралд ашиглах
2	x/ч Б.Батцэц эг	Өнгөт принтер	3 үйлдэлт /Хэвлэх, Хувилах, Сканер/		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх

		Ширээ, сандал	Ком		800,000	Өөрөө сүх
		Дуу хураагу ур	Багтаамж сайтай		300,000	Хурал зөвлөгөөнд архив бо хадгалах
		Сейф	Мэдрэгчтэй цоожтой		600,000	Бичиг баримт хадгалах
		Apple pad	iPad Pro 11" M2 - 256GB Cellular		4,000,000- 6,000,000	Зөөврийн байдлаар ашиглах
3	a/x Б.Наранц ацрал	Intel core i7 10 үеээс дээш	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер н core i3 5 үеийн үзүүлэлттэй
		Зөөври йн принтер	1 үйлдэлт зөөврийн		300,000	Хяналт шалгалтаар ашиглах
		Apple pad	iPad Pro 11" M2 - 256GB Cellular		4,000,000- 6,000,000	Хяналт шалгалтаар ашиглах
		Энгэрий н камер	Хяналт, шалгалт баримтжуу лах		600,000	Хяналт шалгалтаар ашиглах
4	a/x Б.Доржхо рол	Intel core i7 10	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер н core i3 5 үеийн үзүүлэлттэй

		үеээс дээш				
		Энгэрийн камер	Хяналт, шалгалт баримтжуулах		600,000	Хяналт шалгалтаар ашиглах
		Apple pad	iPad Pro 11" M2 - 256GB Cellular		4,000,000-6,000,000	Хяналт шалгалтаар ашиглах
5	а/х 3.Оргилб олд	Intel core i7 10 үеээс дээш, нэмэлт дэлгэцтэй	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер нь core i3 5 үеийн үзүүлэлттэй
		Өнгөт принтер	3 үйлдэлт /Хэвлэх, Хувилах, Сканер/		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
		Apple pad	iPad Pro 11" M2 - 256GB Cellular		4,000,000-6,000,000	Хяналт шалгалтаар ашиглах
6	х/ч Ц.Батбуян	Өнгөт принтер	3 үйлдэлт /Хэвлэх, Хувилах, Сканер/		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
7	х/ч Д.Одхүү	Зургийн камер	Sony alpha 7R		7,000,000	Зураг дарах бичлэг хийх
		Камерны линз	Sony e 18-200 F3.5-6.3		2,000,000	Зураг дарах бичлэг хийх

		Osmo dji	OSMO POCKET 3 CREATOR COMBO		2,800,000	Бичлэг хийх
		Микрофон Bluetooth dji	2 хоёу микрофон		1,250,000	Зургийн аппрат болон утас холбогдох
8	д/а Э.Налжир	Сандал	Түшлэгтэй 360 эргэдэг, 5 дугуйтай		500,000	Өөрөө суух
		Өнгөт принтер	3 үйлдэлт		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
		Дэлгэц	Нэмэлт дэлгэц		700,000	Нэмэлтээр дэлгэц тавих
Санхүү						
9	х/ч Б.Баттуяа	Өнгөт принтер	3 үйлдэлт		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
10	д/ч Д.Ариунана	Компьютер	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер нь core i3 5 үеийн үзүүлэлттэй
11	а/а Ц.Отгончын луу	Notebook	Intel core i7 10 үеээс дээш үзүүлэлттэй		3,500,000	Санхүүгийн программ суух чадалтай

12	а/д Д.Бошхүү	Apple pad	iPad Pro 11" M2 - 256GB Cellular		4,000,000- 6,000,000	Зөөврийн байдлаар ашиглахад
13	х/ч Б.Сүмбэр элсайхан	Гар станц	Хэт богино долгион гар станц 30 ширхэг	KENWOOD, ICOM 	250,000- 500,000	Icom kenwood загварыг
		Дахин дамжуу лагч	Хэт богино долгион		15,000,000	Суурьшлын шинэ бүсэд
14	а/д Э.Халиун	Өнгөт принтер	3 үйлдэлт		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
		Сандал	Түшлэгтэй 360 эргэдэг, 5 дугуйтай		500,000	Өөрөө суух
		Өнгөт принтер	3 үйлдэлт		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
15	Дуудлага хүлээн авагч	Сандал	Түшлэгтэй 360 эргэдэг, 5 дугуйтай		500,000	Өөрөө суух
		Ухаалаг цоож	Албан тасалгаанд		400,000	ШУЗМТ-ын хаалганд

		MEMO RY КАРТ	1 ТИРА		600,000	Дрон гар удирдлагад орно
--	--	--------------------	--------	---	---------	--------------------------

**Эрэн хайх аврах салбар, бүлэг**

16	а/х Л.Эрдэнэ хуяг	Завь	Ком		3,600,000	Уснаас эрэн хайх
		Усны хувцас	Хуурай, нойтон ком		500,000	Уснаас эрэн хайх
		Компью тер	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер н core i3 5 үеийн үзүүлэлттэй
		Өнгөт принтер	3 үйлдэлт		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэ
		Сандал	Түшлэгтэй 360 эргэдэг, 5 дугуйтай		500,000	Өөрөө сүүх
		Шөнийн дуран	Шөнө үүрэг гүйцэтгэх		2,500,000	Эрэн хайх аврах дуудлагаа ашиглах
17	а/д Б.Батсүх	Завь	Ком		3,600,000	Уснаас эрэн хайх

		Усны хувцас	Хуурай, нойтон ком		500,000	Уснаас эрэн хайх
		Компьютер	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер нь core i3 5 үеийн үзүүлэлттэй
		Сандал	Түшлэгтэй 360 эргэдэг, 5 дугуйтай		500,000	Өөрөө суух

**Улсын нөөцийн 114 дүгээр салбар**

18	х/ч Л.Отгончу луун	Өнгөт принтер	3 үйлдэлт		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх
		Сандал	Түшлэгтэй 360 эргэдэг, 5 дугуйтай		500,000	Өөрөө суух
		Хяналтын камер	1 ш		650,000	360 эргэдэг нарны тольтой
		Сургалтын дэлгэц	Ухаалаг дэлгэц		9,000,000	Цахим хуралд оролцох
		Интернет тавиулах	Линк рүтер		300,000	Интернет сүлжээ

		60м цахилга аны утас	Усны худагруу татах		60,000	mod усалгаа
		Цахилг ааны тоолуур	Цогцолбор ын бүтээн байгуулалт, худаг		85,000	Усны худагт
		5 тн усны нөөций н сав	Цогцолбор ын бүтээн байгуулалт, худаг		650,000	mod усалгаа
19	a/x Б.Үүрцайх	Ширээ сандал				Өөрөө суух
		Компью тер	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер н core i3 5 үеийн үзүүлэлттэй
		Шкаф	Шилэн нүүртэй		480,000	Баримт бичиг хадгалах
		Ширээ, сандал	Ком		800,000	Өөрөө суух
20	a/a Н.Намхай догдон	Сандал	Түшлэгтэй 360 эргэдэг, 5 дугуйтай		500,000	Өөрөө суух
		Лац	1		50,000	Хаалга лацдах

		1 үйлдэлт принтер	лазер		680,000	Лазер нэг үйлдэлт
		Ширээ, сандал	Ком		800,000	Өөрөө суух
		Модны нүх ухагч	Мод тарих			Мод тарих
21	Нөөцийн харуул	Ор, гудас	1			Харуулын байранд
		Хөнжил	3			Харуулын байранд
		Гал тогооны ком	1			Харуулын байранд
		Хөлдөө гч	1		800,000	Хүнс хадгалах
		Тэмэр хаалга /бүргэд/	1		700,000	Харуулын байрны үүд
22	Эмч- Сэтгэлзүй ч	Ширээ, сандал	Ком		800,000	Өөрөө суух
		Компью тер	Intel core i7 10 үеээс дээш		3,800,000	Одоог байгаа компьютер н core i3 5 үеийн үзүүлэлттэй

		Шкаф	Шилэн нүүртэй		480,000	Баримт бичиг хадгалах
		Өнгөт принтер	3 үйлдэлт		3,400,000	Автоматаар хоёр талдаа хэвлэх

## **Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж**

### **Зорилт**

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

### **Ажил-өдрийн хуваарь**

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

### **Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсх

ийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

## Долоо. ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын дарга танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | <b>2.1.</b> Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | <b>3.1.</b> Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <b>4.1.</b> Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br><b>4.2.</b> Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | <b>5.1.</b> Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | <b>6.1.</b> Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>7.1.</b> Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br><b>7.2.</b> Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | <b>8.1.</b> Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж   |

үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- |   |  |
|---|--|
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.   |
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.  |

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- |   |  |
|---|--|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.  |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b> | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.  |
| <b>13. Алданги</b>                          | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.  |
| <b>14. Ажил дуусгах</b>                     | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- |                         |  |
|-------------------------|--|
| <b>14. Ажил дуусгах</b> | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. |
|-------------------------|--|

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Гүйцэтгэгч гадна тохижилтүн ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

<b>15.Хүлээж авах</b>	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
<b>16.Эцсийн тооцоо</b>	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
<b>17.Ашиглалт, засвар, үйлчилгээн ий гарын авлага</b>	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.  17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
<b>18.Гэрээг цуцлах</b>	18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.  18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:  (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;  (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг  
цуцалсан  
үед хийх  
төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлэ  
эс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ӨМАОБГ/20240202006
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь зам, талбайн ажлаас бүрдэнэ. Ажлын талбай нь Өмнөговь аймаг, Цогтцэций сумын төвд байршина
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь Өмнөговь аймгийн Онцгой байдлын газар
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр 2024.12.02 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2024.12.31
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа 6 сар байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.5 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 0,5 байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ..... ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0,5-иар тооцно.

# ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах

барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]